

МАЯГТ ТМ-01. ТӨСВИЙН САНАЛ

САНГИЙН САЙД

(мян төг '000)

ХӨТӨЛБӨР: Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага		Гүйцэтгэл		Санал		Төсөөлөл		Өөрчлөлт		
		.1.	.2.	.3.	.4.	.5.	.6.	.7.	.8.	.9.
Код		2021 Гүйц	2022 ХБГ	2023 Хяз	2023 ТЕЗ санал	2024 төсөөлөл	2025 төсөөлөл	2021 гүйц 2022 ХБГ	2022 бат 2023 хяз	2023 хяз 2023 сан
А. Зардлын эдийн засгийн зүйлс										
2101	Цалин хөлс болон урамшил	76,867,947.8	84,273,334.1	97,986,930.1	111,291,410.5	135,775,849.4	167,393,067.4	91%	86%	88%
2102	Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх	10,118,681.9	10,420,524.6	12,132,394.8	15,151,218.2	18,583,710.3	23,019,381.3	97%	86%	80%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,455,022.4	6,446,568.7	8,110,243.5	11,719,604.3	14,431,026.0	18,103,250.3	85%	79%	69%
2104	Хангамж, бараа материалын зардал	3,570,673.6	2,859,680.1	3,563,119.1	5,167,745.7	6,245,589.7	7,615,103.8	125%	80%	69%
2105	Нормативт зардал	771,827.3	3,786,354.9	3,771,800.5	4,909,401.4	6,345,490.0	8,209,134.0	20%	100%	77%
2106	Эд хогшил, урсгал зардал	4,034,176.4	5,508,329.1	5,657,702.0	10,530,122.0	13,173,351.6	16,523,225.8	73%	97%	54%
2107	Томилолт, зочны зардал	905,522.6	838,072.4	1,343,692.4	2,943,667.5	3,378,830.9	3,908,643.4	108%	62%	46%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн АУТХ	294,049,457.5	248,770,724.2	216,164,379.3	414,339,185.0	380,323,799.2	388,593,174.2	118%	115%	52%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,341,793.0	100,642,926.7	103,376,954.1	109,504,977.6	111,854,558.5	114,909,061.6	125%	97%	94%
212	Татаас	77,926,878.9	129,425,307.8	120,690,768.0	168,506,910.0	66,158,013.0	44,920,615.0	60%	107%	72%
213	Урсгал шилжүүлэг	413,694,577.3	1,950,948,660.6	2,170,010,079.8	1,963,009,321.9	1,964,164,089.9	1,967,327,246.7	21%	90%	111%
22	Хөрөнгийн зардал	920,676,226.3	1,349,538,940.0	1,192,353,210.0	4,016,006,881.7	2,802,244,386.1	3,558,454,374.8	68%	113%	30%
##	Бусад	657,093,936.6	923,820,599.8	1,164,692,314.3	1,501,037,443.2	1,415,514,630.3	1,491,797,116.6	71%	79%	78%
НИЙТ, Зардлын зүйл*		2,590,506,721.6	4,817,280,023.0	5,099,853,587.9	8,334,117,889.0	6,938,193,324.9	7,810,773,394.9			

Б. Зардлын зориулалт-арга хэмжээ

								%	%	%
80100	Үндсэн үйл ажиллагаа							%	%	%
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	88,851,493.4	119,335,498.4	118,812,763.8	176,181,642.2	215,535,957.0	266,425,454.3	74%	100%	67%
801030	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	3,859,141.1	5,491,926.3	5,456,808.3	12,229,647.9	14,928,263.2	18,545,908.1	70%	101%	45%
801040	Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	1,169,035,959.3	1,307,895,158.0	1,300,599,909.0	3,880,195,839.2	2,417,896,552.3	2,960,199,062.5	89%	101%	34%
801050	Гадаад тусламжаар гүйцэтгэх ажил, үйлчилгээ	163,191,439.7	298,519,400.0	298,519,400.0	588,066,962.4	679,568,258.5	810,908,815.4	55%	100%	51%
802050	Мэдээлэл, сурталчилгааны зардал	298,920.7	724,795.8	874,223.9	1,101,646.8	1,214,018.2	1,352,180.4	41%	83%	79%
802160	Улсын зэрэглэл тогтоох үйлчилгээ	703,784.0	843,844.9	1,152,900.0	1,224,300.0	1,174,800.0	1,196,800.0	83%	73%	94%
802190	Харуул, хамгаалалтын зардал	863,121.3	1,035,002.6	1,035,002.6	1,278,599.8	1,534,357.6	1,858,055.1	83%	100%	81%
802200	Холбооны суваг ашигласны хөлс	3,119,371.8	3,137,865.8	3,137,865.8	4,927,469.3	5,636,560.8	6,537,026.5	99%	100%	64%
802260	Байр ашиглалтын үйлчилгээ	317,138.6	985,516.0	985,516.0	1,299,499.7	1,467,092.2	1,628,014.3	32%	100%	76%
802280	Цахим хуудасны бүртгэлийн хураамж	65,846.9	51,146.1	51,146.1	69,300.0	69,300.0	69,300.0	129%	100%	74%
803050	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	19,827.2	20,000.0	-	25,000.0	32,500.0	42,250.0	99%		0%
803130	Дээж худалдан авах	2,188.0	317,490.5	317,490.5	2,240,000.0	2,912,000.0	3,785,600.0	1%	100%	14%
804040	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	71,476,878.9	124,207,848.8	115,473,309.0	152,506,910.0	50,158,013.0	28,920,615.0	58%	108%	76%
805010	Санхүүгийн дэмжлэг	179,181,641.8	176,496,167.3	176,496,167.3	180,581,302.5	179,181,641.8	179,181,641.8	102%	100%	98%
805030	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	219,181,640.7	219,181,640.7	225,644,423.8	219,181,640.7	219,181,640.7	219,181,640.7	100%	97%	103%
805070	үндэсний олон нийтийн мэдээллийн үйл ажиллагааг дэ	6,450,000.0	5,217,459.0	5,217,459.0	16,000,000.0	16,000,000.0	16,000,000.0	124%	100%	33%
805090	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэл	356,468.8	1,679,885.6	1,679,885.6	1,694,248.2	1,820,709.6	1,855,809.6	21%	100%	99%
805220	Зээл - ОУ-ын байгууллагаас сумдын ОНХСанд олгох ор	8,322,506.0	-	6,999,891.0	-	-	-		0%	

805230	Тусламж - ОУ-ын байгууллагаас сумдын ОНХСанд олг	756,700.0	-	-	-	-	-			
807040	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хсг	177,450.0	211,500.0	198,000.0	252,000.0	252,000.0	252,000.0			79%
808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	3,612,174.0	3,027,067.0	238,809,163.9	10,838,005.5	13,250,611.3	16,359,905.1	119%	1%	2203%
808110	Нүүлгэн шилжүүлэх зардал	28,473.7	22,790.8	22,790.8	28,000.0	36,400.0	47,320.0	125%	100%	81%
808320	Малын индексжүүлсэн даатгалын шимтгэл	415,816.0	-	-	-	-	-			
808330	Жирэмсэн болон төрсөн эхчүүдийн НДШ	-	-	-	109,725.0	125,086.5	143,849.5			0%
809180	Бусад	54,815,317.9	234,538,940.0	77,353,210.0	381,570,951.8	407,903,451.8	407,903,451.8	23%	303%	20%
811010	Засгийн газрын нөөц хөрөнгө	100,000,000.0	95,000,000.0	95,000,000.0	95,000,000.0	95,000,000.0	95,000,000.0	105%	100%	100%
812010	Дүрмийн сан	2,315,117.0	5,000,000.0	5,000,000.0	5,000,000.0	-	-	46%	100%	100%
814040	Дамжуулан зээлдүүлсэн зээл	(330,732,063.0)	(189,312,560.0)	(235,083,580.0)	(201,275,140.0)	(222,836,626.1)	(207,028,271.1)	175%	81%	117%
814050	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	-	(80,942,100.0)	(80,942,100.0)	(80,942,100.0)	-	-	0%	100%	100%
814090	Засгийн газрын үнэт цаас	616,757,095.3	698,639,983.2	905,577,768.5	934,547,190.0	948,210,739.3	1,086,297,506.4	88%	77%	97%
814100	Засгийн газрын зээл	212,873,990.9	210,435,276.6	290,140,225.8	361,153,590.0	309,702,056.8	314,899,224.8	101%	73%	80%
815040	УИХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг	1,690,180.0	760,000.0	638,716.1	760,000.0	760,000.0	760,000.0	222%	119%	84%
815470	Хөрөнгө оруулагчдын харилцааг идэвхижүүлэх	-	181,193.7	215,599.7	215,599.7	215,599.7	215,599.7	0%	84%	100%
823240	Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх үй	7,771.5	500,000.0	420,208.0	500,000.0	500,000.0	500,000.0	2%	119%	84%
829020	Гадаад харилцааг эдийн засагжуулах	151,411.6	7,975,655.6	4,002,286.0	5,520,900.0	1,650,000.0	1,650,000.0	2%	199%	72%
831050	Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах	876,505.9	1,680,831.9	1,680,831.9	2,000,000.0	2,000,000.0	2,000,000.0	52%	100%	84%
831080	Төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардал	-	119,566.3	119,566.3	132,000.0	119,566.3	119,566.3	0%	100%	91%
831100	Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлт	576,353.1	505,407.6	505,407.6	666,000.0	666,000.0	666,000.0	114%	100%	76%
831120	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	9,305,133.0	11,295,886.7	11,295,886.7	25,887,358.3	18,464,104.4	18,909,371.7	82%	100%	44%
831140	Блүмбергийн мэдээллийн системийн төлбөр	217,887.6	251,625.0	245,700.0	257,400.0	270,270.0	297,297.0	87%	102%	95%
832010	Ангилалдаагүй бусад зориулалт, арга хэмжээ	1,364,038.9	2,655,912.8	2,655,912.8	3,500,000.0	4,000,000.0	4,500,000.0	51%	100%	76%
807060	Ирээдүйн өв сан /хүүхдийн мөнгөн тэтгэмж/	-	1,549,592,400.0	1,519,543,832.1	1,549,592,400.0	1,549,592,400.0	1,549,592,400.0	0%	102%	98%

НИЙТ, Зардлын зориулалт -арга хэмжээ *	2,590,506,721.6	4,817,280,023.0	5,099,853,587.9	8,334,117,889.0	6,938,193,324.9	7,810,773,394.9			
--	-----------------	-----------------	-----------------	-----------------	-----------------	-----------------	--	--	--

В. Санхүүжүүлэх эх үүсвэр

31	Улсын төсөв	1,586,694,797.4	1,927,290,577.8	2,285,979,088.6	2,594,752,780.2	2,509,895,593.0	2,692,596,740.9	82%	84%	88%
310003	ЗГ-ын тусгай сан									
310002	Тусгай зориулалтын шилжүүлэг									
35	Үйл ажиллагааны орлого	848,021,905.6	1,312,132,305.2	1,311,836,947.2	3,883,922,986.4	2,421,973,699.5	2,964,703,709.7	65%	100%	34%
36	Тусламж	155,790,018.6	298,519,400.0	298,519,400.0	588,066,962.4	679,568,258.5	810,908,815.4	52%	100%	51%
37	Бусад эх үүсвэр	-	(270,254,660.0)	(316,025,680.0)	(282,217,240.0)	(222,836,626.1)	(207,028,271.1)	0%	86%	112%
34	Хуримтлалын сангийн төсвөөс санхүүжих									
340002	Ирээдүйн өв сангаас санхүүжих	-	1,549,592,400.0	1,519,543,832.1	1,549,592,400.0	1,549,592,400.0	1,549,592,400.0	0%	102%	98%

НИЙТ, Эх үүсвэр	2,590,506,721.6	4,817,280,023.0	5,099,853,587.9	8,334,117,889.0	6,938,193,324.9	7,810,773,394.9			
-----------------	-----------------	-----------------	-----------------	-----------------	-----------------	-----------------	--	--	--

Г.Хөтөлбөрийн орон тооны мэдээлэл

1.Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,618.0	1,618.0	1,618.0	1,618.0	1,618.0	1,618.0	100%	100%	100%
2.Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1,904.0	1,904.0	1,904.0	1,904.0	1,904.0	1,904.0	100%	100%	100%
3.Ажлын албаны албан хаагч (АА)	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	100%	100%	100%
4. Улс төрийн албан хаагч (УТ)	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	100%	100%	100%
5. Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	821.0	821.0	821.0	821.0	821.0	821.0	100%	100%	100%
6. Гэрээт ажилтан	56.0	56.0	56.0	56.0	56.0	56.0	100%	100%	100%

Нийт, Орон тоо	4,446.0	4,446.0	4,446.0	4,446.0	4,446.0	4,446.0			
----------------	---------	---------	---------	---------	---------	---------	--	--	--

Е.Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт

20.1 Санхүү, төсөв, эдийн засгийн нэгдсэн удирдлага								%	%	%
20.1.1	Монгол Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төсөл боловсруулж							%	%	%
1	Улс орон нутгийн төсөвт орох татварын орлогын төлөвлөгөөний биелэлт									
2	Өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагд	57.7	70	70	70	70	70	82%	100%	100%
3	Өмнөх онуудын хяналт шалгалтаар ногдуулсан өр барагдуу	64.5	50	50	50	50	50	129%	100%	100%
4	Тайлант хугацааны татварын тайлангийнногдол өр барагдуу	80.5	80	80	80	80	80	101%	100%	100%
5	Тайлант хугацааны хяналт шалгалтын ногдол өр барагдуул	32.7	60	60	60	60	60	55%	100%	100%
6	Татварын цахим тайлан хүлээн авалт/хувь/	67.7	78	80	80	82	84	87%	98%	100%
7	Алдагдалтай буюу "Х" тайлан тушаалтын бууралт/хувь/	1	0.6-1	0.06-1	0.6-1	0.06-1	0.06-1			
8	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчийн бааз су	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	100%	100%	100%
9	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн баазыг нэмэгдү	8	8	8	8	8	8	100%	100%	100%
10	Бусад төрлийн татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	100%	100%	100%
11	Хөтөлбөр 1: Гаалийн хяналтын эрсдлийн удирдлагыг нэвтр	59	59	64	64	69	74	100%	92%	100%
12	Хөтөлбөр 2: Үндэсний аюулгүй байдлыг хангах хууль бус	5	5	5	5	5	5	100%	100%	100%
13	Хөтөлбөр 3: Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2	2	3	3	3	3	100%	67%	100%

ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд санхүүгийн бодлого, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын тэнцвэртэй байдал, нийгэм, эдийн засгийн салбаруудын харилцан уялдаа холбоог хангах, нягтлан бодох бүртгэл, дотоод

Ё. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх гол зорилтууд (дунд хугацаагаар)

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд санхүүгийн бодлого, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын тэнцвэртэй байдал, нийгэм, эдийн засгийн салбаруудын харилцан уялдаа холбоог хангах, нягтлан бодох бүртгэл, дотоод аудит, худалдан авах ажиллагааны бодлого, төрийн сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт болон зээл, тусламжийн санхүүжилтийн хүрээнд үүрэг хүлээж, Засгийн газрыг зөвлөгөө мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллана. Мөн МУ-ын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор Коронавируст халдвар /Ковид-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх зорилготой "Шинэ сэргэлтийн бодлого"-ийг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, боомтын бүтээн байгуулалтын ажлыг түргэвчлүүлэн, тоног төхөөрөмжийн угсралтыг зэрэгцүүлж хийхээр үе шаттай зохион байгуулагдаж буй төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан тооцон төлөвлөлөө.

Ж. Зардлын тойм-зардлын дүн шинжилгээ

Татварын алба нь 2023 онд " ЦАХИМ ТАТВАРЫН АЛБА" II үе шатхэрэгжүүлэхээр дээрх 5 зорилтуудыг тавин ажиллана. Татварын 33 алба 1855 ажилтан, албан хаагч хийж гүйцэтгэхээр төсвийн төслийг боловсруулсан бөгөөд үйл ажиллагааны урсгал зардалд нийт 64,949.4 сая, хөрөнгө оруулалтын зардалд 21,329.0 сая төгрөг, нийт 86,278.4 сая төгрөг зарцуулах төсвийн төлөвлөлт хийгдсэн.

3. Төсвийн хязгаараас давсан саналын үндэслэл, тайлбар, нотолгоо

1. Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалын зардлын талаар

Татварын албаны 2023 оны цалин хөлс болон урамшуулалын зардлыг 1855 орон тоотойгоор төлөвлөсөн ба нийт дүнгээр 5,998,059.6 мянган төгрөгөөр буюу үндсэн цалин 238,632.5 мянган төгрөг, нэмэгдэл цалингийн зардал 389,047.7 мянган төгрөг, унаа хоолны хөнгөлөлтийн зардал 1,369,312.0 мянган төгрөг, урамшуулалын зардал 4,001,067.4 мянган төгрөгөөр тус тус хязгаараас нэмэгдсэн нь дараах шалтгаантай холбоотой байна. Үүнд:

Үндсэн цалин: Засгийн газрын 275,276, 107 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын цалин тогтоомжийг төрийн албанд ажилласан хугацаатай уялдуулан төсвийн шууд захирагч нараас тогтоон ирүүлсэн саналыг үндэслэн тооцосон бөгөөд албан хаагчдын цалингийн шатлал ахисантай холбоотой нэмэгдсэн болно.

Нэмэгдэл цалин: Засгийн газрын 382, 107 дугаар тогтоол, УИХ-ын 21 дүгээр тогтоол, 2020 оны ЗГ-ын 151 дүгээр тогтоолын дагуу тооцсон ба цалингийн шатлал ахисан, төрийн албаны зэрэг дэв тогтоохтой холбоотой өсөлтийг нэмж тооцон төсөвлөсөнтэй холбоотой байна.

Унаа хоолны хөнгөлөлт: Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 8.3-т албан хаагчийн нэг өдрийн хоолны мөнгө 8000 төгрөг, унаа 2000 төгрөг байхаар тогтоосныг баримтлан төсөвлөсөнтэй холбоотойгоор 1,369,312.0 мянган төгрөгөөр төсөв хязгаараас давж байгаа болно.

Урамшуулал: Татварын ерөнхий хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалтыг үндэслэн Сангийн сайдын 2020 оны 09 сарын 03-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам"-ын 1.2-д заасны дагуу Татварын улсын байцаагчийн сар бүр олгох үр дүнгийн шагналыг сарын үндсэн цалингийн 50%-иас хэтрэхгүй байх журамласны дагуу Татварын улсын байцаагчид сар бүр олгох урамшуулалын зардлыг үндсэн цалингийн 50%-иар, ЗГ-ын 5 дугаар тогтоолын дагуу Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажлын үр дүнгийн урамшууллыг улиралд 40%-иар тооцож төлөвлөсөн бөгөөд урамшуулалын зардал бодит тооцоогоор 3,994,206.5 мянган төгрөгөөр нэмэгдэж байна.

Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйл заасны дагуу татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Татварын албаны дэргэд Маргаан таслах зөвлөл ажилладаг, зөвлөлийн гишүүдийн цалинд 409,860.0 мянган төгрөг зарцуулахаар байгааг төсөвлөв. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу нийт албан хаагчдын цалин хөлсийг тооцож төсөвлөсөн. мөн Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулалыг нэмж олгох, Монгол улсын засгийн газрын 198 дугаар тогтоолоор "Хятад, Монголын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ээр Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошууны хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын Бямба, Ням гараг болон нийтээр тэмдэглэх баярын өдөр ажиллуулахад гарах цалин хөлсний зардлыг Засгийн газраас шийдвэрлэж байхаар тусгасан. Мөн Ковид-19 цар тахлын нөлөөтэй холбоотойгоор Гашуунсухайт, Шивээхүрэн, Алтанбулаг, Замын-Үүд, Ханги зэрэг боомтууд болон зарим гүний гаалийн байгууллагуудын ажиллах цагийг нэмэгдүүлснээр албан хаагчидад илүү цаг олгохоор нэмж төсөвлөсөн.

2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын талаар

Тогтмол зардал: Тогтмол зардал /гэрэл, цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус/ нь төсвийн хязгаараас 396,135.4 мянган төгрөгөөр нэмэгдэх болсон нь дараах шалтгаантай. Үүнд: 2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн 9 давхар 6800 м2 конторын барилга шинээр ашиглалтад орно, Булган аймгийн татварын хэлтсийн барилгад өргөтгөл хийгдсэнтэй холбоотой тогтмол зардал нэмэгдэж байгааг тооцсон, одоо мөрдөгдөж байгаа үнэ тариф, тогтоолыг үндэслэн төсөвлөв. **Байрны түрээс:** Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн конторын байрыг ашиглалтанд орох хүртэл байрны түрээсийг төсөвлөсөн ба түрээслэгч байгууллагууд 2023 онд түрээсийн зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалан түрээсийн үнийг нэмэгдүүлэхээр санал ирүүлсэн, түрээсийн төлбөрийн өнөөгийн зах зээлийн үнийн дундажийг судлан тооцож төлөвлөсөн, 2023 онд барилга байгууламжид хийх их засвар, шинэчлэлтэй холбоотойгоор байр түр хугацаагаар түрээслэх зардлыг тооцож төсөвлөсөнтэй холбоотой төсөв нэмэгдэхээр байна. Хөшигийн хөндий дэх Нэг цэгийн үйлчилгээний барилга, байгууламжууд болон төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт, Боршоо боомтуудын бүтээн байгуулалтууд 2022 онд ашиглалтад орж байгаатай холбоотойгоор байр ашиглалтын зардал болон бусад холбогдох урсгал зардлыг нэмэгдүүлж төсөвлөсөн.

3. Хангамж бараа материалын зардлын талаар

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтуудын хүрээнд 33-н Татварын албадын хэмжээнд Хангамж, бараа материалын зардлыг 2023 оны суурь түвшингээс нийт дүнгээр 1,731,059.3 мянган төгрөгөөр хязгаараас нэмэгдэж байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд: **Бичиг хэрэг:** Бичиг хэргийн материалын зах зээлийн үнийн өсөлт, Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад зайлшгүй шаардлагатай зардлын тооцоолыг албадаас тооцож ирүүлсний дагуу төсөвлөсөнтэй холбоотой байна. Шатахууны зардал: Татвар хуоаах, өр барагдуулах, хууль хэрэгжүүлэх ажлыг Улсын хэмжээнд зохион байгуулахад шаардлагатай автомашины шатах тослох материалын тооцоог хийж, үнийн өсөлттэй уялдуулан тооцоолсонтой холбоотой болно.

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр: Татварын албанаас Татвар төлөгчид зайнаас үйлчилгээ үкүүлэх, өр барагдуулах, тайлан хүлээн авахтай холбоотой МАСС МЕССЕЖ үйлчилгээний зардалд 485,931.3 мянган төгрөг нэмж шаардагдаж байгааг тооцож төсөвлөв. **Ном, хэвлэл:** Татварын хуулийг хэрэгжүүлэхдээ холбоотойгоор мэргэжлийн сонин, сэтгүүл захиалахтай холбоотой 33 албаны зардлыг тооцож төсөвлөв.

4. Нормативт зардлын талаар

Эм бэлдмэл ангилалд: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжин ирсэнтэй холбоотой ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис худалдан авах зардал, гаалийн болон хорио цээрийн лабораториудад шаардлагатай материалын зардлыг мөн гаалийн албаны эрэлч ноход жилдээ 1 удаа галзуугын вакцин мөн олон цэнэгт вакцинд хамруулах улирал тутамд гадна болон дотор паразитын эсрэг эм бэлдмэл мөн шаардлагатай хэрэглэгдэх эм бэлдмэлээр хангах, нохойн хоолны сав гадна талбай үүр ариутгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн бэлдмэл худалдан авах зардлыг тус тус төсөвлөсөн. Хоол хүнс ангилалд албаны 50 гаруй эрэлч нохойн зориулалтын хоолны зардлыг төсөвлөсөн. Эрэлч нохойн өдрийн хоолны норм нь том нохойнд 1 удаадаа 750 гр ба жижиг нохойнд 500 грамаар бодогдож олгодог. Уг тогтоосон норм нь нохойн өдөр тутмын хэрэгцээг хангахад дутагдалтай байдаг учраас 2 дахин нэмэгдүүлэх, мөн үйлдвэрийн хоолнууд нь өвлийн улиралд нохойн биеийн дулааныг хадгалахад муу байдаг ба нэмэлтээр мах махан бүтээгдэхүүнүүдийг авч хэрэглэх шаардлагатай байна гэдэг саналыг эрэлч нохойн албанаас ирүүлж 1 жилд өвлийн улиралд 50кг түүхий мах, 700 ширхэг малын өвчүү, 700 ширхэг дотор гэдсийг цуглуулан авч эрэлч ноходыг хооллодог. Нэг кг нохойн зориулалтын хоолны зах зээлийн дундаж үнэ 8000 төгрөг байна. Тиймээс эрэлч нохойн хоолны норм нормативыг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн хоол хүнс ангилалд лабораторийн албан хаагчид болон ариутгагч нарын хор саармагжуулах бүтээгдэхүүний зардлыг төсөвлөсөн. Нормын хувцас зөөлөн эдлэл ангилалд нийт 1805 төрийн тусгай албан хаагчийн дүрэмт хувцасны хангалтад 2,6 тэрбум төгрөг төсөвлөсөн. Албан хаагчдын дүрэмт хувцасны хангалтад олгодог өвлийн болон хавар намрын хувцасны хангалт 2018 оноос хойш хийгдээгүй, 2019-2022 онуудад зохион байгуулсан худалдан авалтууд шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй мөн нэгч оролцогч материал ирүүлээгүй шалтгаануудаар цуцлагдсан тул 2023 онд 4-5 нэр төрлийн дүрэмт хувцасны худалдан авалтыг зохион байгуулахаар төсөвлөсөн.

5. Эд хогшил, урсгал зардлын талаар

Урсгал зардал: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зориулалтаар ашиглахаар худалдан авсан багаж техник хэрэгслийн зардлууд болон албан хэрэгцээнд ашиглагдах компьютер, принтер, скайнер зэрэг тоног төхөөрөмжийг цөөн тоогоор худалдан авах зардлууд, урсгал засварын зардалд “Шинэ сэргэлтийн бодлого” хөтөлбөрийн 1 дүгээрт тусгагдсан “Боомтын сэргэлт” багц асуудлын 1.1.5-д "Боомтуудын үндсэн байгууламж /эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, интернэтийн сүлжээ, гаалийн лаборатори, зорчигч болон ачаа тээврийн терминал/-ийг өргөтгөн шинэчилж, зорчигч аялах, албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэх" гэж тусгагдасны дагуу хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хангахтай холбогдсон зардлууд багтсан.

6.Томилолт зочны зардлын талаар

Дотоод албан томилолтын зардал суурь түвшингээс 320,325.6 мянган төгрөгөөр өссөн 2023 онд хуулийн хэрэгжилтийг хангахуулах, татвар цуглуулах, татварын хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэхэд дотоодод томилолтоор ажиллах тооцоонд үндэслэн Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 тоот тушаалаар батлагдсан албан томилолтын зардлын шинэчлэгдсэн тарифын дагуу төсөвлөсөнтэй холбоотойгоор хязгаараас нэмэгдсэн болно. **Томилолт, зочны зардал:** Гаалийн байгууллага нь харьяа гаалийн газар хороодод хяналт шалгалт хийх, дотоод аудит болон бусад боомтын үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор харьяа 18 газар, хороонд албан томилолтоор ажилладаг тул томилолтын зардлыг Сангийн сайдын 2022 оны 12 дугаар тушаалаар батлагдсан тарифаар, шатахууны зардлыг зах зээлийн ханшаар тооцон төсөвлөсөн. Мөн гаалийн шинэчлэлийн хүрээнд харьяа боомтууд дээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлууд, төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалтын ажлын явцтай тухайн боомт дээр очиж танилцах, хяналт тавих зайлшгүй шаардлага үүсч байгаа тул тус зардлыг нэмэгдүүлж төсөвлөсөн.

7.Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн төсвийн талаар

Бусдаар гүйцэтгэтгүүлсэн нь ажил, үйлчилгээний төлбөр, хураамж нь хязгаараас 657,163.4 мянган төгрөгөөр нь давсан дараах шалтгаантай байна. **Даатгалын үйлчилгээ** : Заавал даатгуулах албан журмын даатгал төлөвлөсөнтэй холбоотойгоор 28,598.7 мянган төгрөг хязгаараа давсан. **Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ**: ЕХ-ийн 60 дугаар зүйл Хөрөнгө болон авлага битүүмжлэх, битүүмжилсэн хөрөнгийг хураах, битүүмжилсэн хөрөнгө мөнгөн хэлбэрт шилжүүлэх дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой зардал шинээр нэмэгдэж төсөвлөгдсөнтэй холбоотой байна.

Байр ашиглалтын үйлчилгээ: ТЕГ, НТГ, төвийн 6 дүүргийн Татварын албадын байр ашиглалтын үйлчилгээний ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх болсонтой холбоотойгоор 1м2 -н үйлчилгээний дундаж үнэ хөлс 3500 төгрөг байгааг талбайн хэмжээнд ногдуулан төсөвлөсөнтэй холбоотой болно. **Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж**:

1. Гаалийн мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлийн хүрээнд Азийн хөгжлийн банкаас санхүүжүүлэн худалдан авсан тоног төхөөрөмж, програм хангамж болон байгууллагын дотоод үйл ажиллагааны програм хангамжуудын албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөр;

2. Гаалийн лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулах олон улсын зөвлөх үйлчилгээний багтай 2020 онд гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд коронавирусын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гаалийн төв болон салбар лабораторийн барилгууд хугацаа хоцорч ашиглалтад орсон, мөн тоног төхөөрөмжүүдийн нийлүүлэлтийн хугацаа хойшлогдсон зэргээс шалтгаалан олон улсын зөвлөх үйлчилгээний багын төлөвлөсөн ажил хойшлогдож, гэрээний хугацааг 2024 оны 06 дугаар сар хүртэл сунгасан тул нэмэлт санхүүжилт;

3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжин ирсэнтэй холбоотой хорио цээрийн хяналт, шалгалтад ашиглагддаг 27 ширхэг маягтын хэвлүүлэх зардал, болон дэлхий нийтэд тархаад байгаа цар тахал, халдварт өвчинтэй холбоотой Олон улсад шуурхай мэдээлэх хүний хөл хориот өвчнөөс урьдчилан сэргийлэх, харну арга хэмжээ авах улсын хилээр нэвтэрч буй зорчигчдоор бөглүүлэх “Эрүүл мэндийн мэдүүлгийн хуудас” хэвлүүлэх зардлыг тооцож төсөвлөсөн. Мөн гаалийн хяналт шалгалтын зорилгоор ашиглагддаг "Зорчигчийн гаалийн мэдүүлгийн маягт", хатуу дугаар бүхий нэг удаагийн троссон ломбоны худалдан авалт 2020 оноос хойш хийгдээгүй бөгөөд 2023 онд худалдан авалтыг зайлшгүй зохион байгуулах шаардлагатай байгаа тул уг зардлыг тооцож төсөвлөсөн.

8.Мэдээлэл технологийн үйлчилгээ

2022 онд Fortigate Firewall 200 Азийн хөгжлийн банкны “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн хүрээнд 2020 онд Татварын ерөнхий газарт 4 ширхэг Fortigate 2000E загварын сүлжээний галт хана төхөөрөмжийг 1 жилийн лиценз-(Unified (UTP) Threat Protection (24x7 FortiCare plus Application Control, IPS, AV, Web Filtering and Antispam, FortiSandbox Cloud) for 1 Year support)-тэйгээр худалдан авч ТУНС-д хандах сүлжээний тохируулга, хамгаалалтын зориулалттайгаар байршуулан ашиглаж байна. Сүлжээний хэвийн ажиллагааг хангахад лицензийг ашиглах зайлшгүй шаардлагын хүрээнд 2021 оны 05 сарын 01-ний өдрөөс 2022 оны 05 сарын 01-ний өдрийг хүртэлх сунгалтыг АХБ-ны санхүүжилтээр хийгдсэн бөгөөд цаашид уг санхүүжилтээр дахин сунгалт хийх боломжгүй болсон. Лицензийг 3 жилээр сунгах нь төсөв санхүүгийн хувьд тодорхой хэмжээний хэмнэлттэй тул 3 жилээр сунгах 711,202,800 төгрөгийг төсөвлөсөн. Үндэсний дата төв болон Сангийн яаманд байрлах ТУНС-ийн үндсэн болон нөөц сайтуудын сүлжээний хамгаалалтын төхөөрөмжийн өргөтгөл хийсэн модулийн лицензийн төлбөр FortiSandbox FSA-3000F license 12 months, FortiADC 1000F license нийт 657,878,400 төгрөг шинээр 2023 онд нэмж төсөвлөгдөж байна.

9. Санхүүгийн хүүгийн зардал

Монгол Улсын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд хүүгийн зардлын нийт дүнг 1,195.7 тэрбум төгрөгтэй тэнцүү байхаар тооцоологдож байсан. Энэхүү тооцоог хийхэд ам.доллартой харьцах төгрөгийн ханш 3190 төгрөг байхаар, хөвөгч хүүтэй гадаад зээлийн хувьсах хүү болох ЛИБОР болон SOFR хүүгийн түвшнийг харгалзан 3.0% болон 1.0% байхаар тооцоолсон.

Дэлхийн эдийн засгийн хямрал болон Монгол Улсад тохиолдож буй хилийн хязгаарлалт, хөрш орны нөхцөл байдал зэргээс хамаарч тухайн ханш болон олон улсын хувьсагч хүүгийн түвшин өсч 2022 оны 08 дугаар сарын байдлаар ам.доллартой харьцах төгрөгийн ханш 3183.5 төгрөг (2022.08.13), ЛИБОР хүүгийн түвшин 3.6%, SOFR хүүгийн түвшин 3.1%-тай тэнцэж байна. Иймд дээрх тооцоонд ашигласан суурь үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцох шаардлага гарсан.

Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд хүүгийн зардлыг тооцохдоо ам.доллартой харьцах төгрөгийн ханш 3300 төгрөг, ЛИБОР хүүгийн түвшнийг 5.0%, SOFR хүүгийн түвшнийг 4.5%-тай тэнцүү байх төсөөлөлтэйгөөр тооцоолол хийхэд гадаад зээлийн хүүгийн түвшин 290.1 тэрбум төгрөгөөс 361.2 тэрбум төгрөгт хүрч өссөн, гадаад үнэт цаасны хүүгийн түвшин 576.0 тэрбум төгрөгөөс 606.5 тэрбум төгрөгт хүрч нийт гадаад өрийн хүүгийн зардал 71.0 тэрбум төгрөгөөр өсөх төлөвтэй байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хүлээгдэж буй гүйцэтгэл, Төв төрийн сангийн үлдэгдэл зэргээс шалтгаалж 2,064.3 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний дотоод үнэт цаас арилжаалахаар төсөөлж байсныг 1,800.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээтэй арилжаалахаар болгон бууруулсан бөгөөд 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр төсвийн алдагдал нөхөх зорилгоор “Хадгаламжийн даатгалын корпораци”-д хаалттай арилжаалсан 300.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг Монголбанкны бодлогын хүү (10%)-нээс 2 дахин бага хүүтэйгээр арилжаалсан зэргээс шалтгаалж 235.0 тэрбум төгрөгөөс 203.6 тэрбум төгрөгт хүрч нийт 31.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.